

“ГАМШГААС ХАМГААЛАХ САЙН ДУРЫН АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ЖУРАМ”-ЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2017.10.27

1. Журмын төсөл боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлага:

Аливаа гамшгийн үед мэргэжлийн аврах байгууллагын тусламж иртэл дийлэнх тохиолдолд иргэд өөрсдийгөө болон бусдыг авран хамгаалж, учирч болох эрсдэлийг бууруулж байгаа нь улс орнуудад тохиолдсон гамшгийн байдал, түүнийг даван туулж байгаа туршлага, сургамж харуулж байгаа бөгөөд гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед аврах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд сайн дурын ажилтнуудын оролцох оролцоо, гүйцэтгэх үүрэг дэлхий нийтэд улам бүр өсөн нэмэгдсээр байна.

Манай Улсад гамшгийн эрсдэлийг бууруулах сайн дурын ажиллагааг зохицуулах үндэсний бодлого, стратеги, эрх зүйн орчин бүрдээгүй, Засгийн газарт сайн дурын үйл ажиллагааг хариуцсан бүтэц байхгүй байгаа ч гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд иргэд, олон нийт, бүлэг нөхөрлөлийн түвшинд сайн дурын оролцоо тодорхой хэмжээгээр байсаар ирсэн.

Гамшгаас хамгаалах тухай хууль шинэчлэн батлагдсанаар гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагаа, сайн дурын хэсгийн эрх зүйн зохицуулалт, эрх, үүрэг тодорхой болсон.

Тухайлбал:

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд сайн дурын хэсгийн нэр томъёог шинээр оруулж, 24 дүгээр зүйлд сайн дурын хэсгийг гамшгаас хамгаалах хүч хэрэгсэлд хамааруулж, 32 дугаар зүйлд сайн дурын хэсгийг байгуулах асуудлыг, 36 дугаар зүйлд гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрх, үүрэг, нийгмийн баталгааг тусгасан. Мөн Галын аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлд гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг байгуулах, санхүүжүүлэх, сайн дурын хэсгийн ажилтны нийгмийн хамгааллын асуудлыг тусгасан.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрт олон нийтэд суурилсан гамшгаас хамгаалах менежментийг хөгжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоог хангах чиглэлээр зорилга, зорилтууд тусгагдсан.

Мөн нийслэлийн зарим дүүрэг, зарим аймаг, сумдад сайн дурын хэсэг байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Иймд Гамшгаас хамгаалах тухай хууль, гамшгаас хамгаалах төрийн бодлого, үндэсний хөтөлбөр болон бусад хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилттой уялдуулан Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”-ыг шинэчилж боловсронгуй болгох шаардлага бий болж байна.

2. Журамд орсон өөрчлөлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Энэхүү журам нь гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулахад үүсэх

харилцааг зохицуулах зорилготой бөгөөд “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”-д дараах өөрчлөлтийг оруулж дахин боловсрууллаа. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн журамд хэрэглэсэн нэр томъёонуудыг хассан.
2. Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн журмын 6.3-т заасан сайн дурын ажилтанд хориглох 5 заалтыг хасаж, сайн дурын хэсгийн хүлээх үүрэг хэсэгт нэгтгэсэн.
3. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааг бие дааж бус сайн дурын хэсэг, бүлгийн зохион байгуулалтад орж явуулахаар өөрчилсөн.
4. Журмын хэл зүйн найруулгыг засаж сайжруулсан.

Энэхүү журмын төсөл нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актад хамаарах тул олон нийтээс санал аван, нөлөөллийн шинжилгээ хийж, Монгол Улсын Шадар сайдаар батлуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх болно.

Иймд журмын төсөлтэй танилцан холбогдох саналаа бичгээр Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны газарт, цахимаар bodlogo@nema.gov.mn хаяг руу илгээнэ үү.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Монгол Улсын Шадар сайдын 2017 оны
.... дугаар сарын-ны өдрийн дугаар
тушаалын хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ САЙН ДУРЫН АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаа, сайн дурын хэсгийн зохион байгуулалт, сургалт дадлага, эрх зүйн зохицуулалт, гамшгаас хамгаалах үйл ажиллагаан дахь оролцоог хангахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Сайн дурын хэсгийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж байна.

1.3. Сайн дурын хэсгийн ажилтан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцоход хууль тогтоомжийн дагуу эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

1.4. Сайн дурын хэсгийн ажилтныг тусгай сургалтанд хамруулан гамшгаас хамгаалах чиглэлээр мэдлэг, чадвар эзэмшүүлж сайн дурын аврагч, гал сөнөөгч бэлтгэнэ.

Хоёр. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны үндсэн чиглэл

2.1. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаа нь дараах үндсэн чиглэлтэй байна:

2.1.1.гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах;

2.1.2.гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах;

2.1.3.гамшгийн дараах хүмүүнлэгийн тусламж үйлчилгээ, сэргээн босгох ажиллагаа;

2.1.4.гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн чадавхыг бэхжүүлэх

Гурав. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны зарчим

3.1. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаа нь дараах зарчимтай байна:

3.1.1. хүмүүнлэг энэрэнгүй, шуурхай, байх;

3.1.2. нийтийн эрх ашгийн төлөө, нэгдмэл байх;

3.1.3. шударга, ашгийн төлөө бус байх.

Дөрөв. Сайн дурын хэсгийн ажилтанд тавигдах ерөнхий шаардлага

4.1.Сайн дурын хэсгийн ажилтанд дараах ерөнхий шаардлага тавигдана.

4.1.1.Монгол Улсын иргэн, тус улсад хууль ёсоор оршин сууж байгаа гадаад улсын иргэн байна;

- 4.1.2.Насны хязгаар 18-60 байна;
- 4.1.3.Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаа явуулах чиглэлээр мэдлэг, чадвартай байх;
- 4.1.4.Сэтгэцийн болон бие бялдрын хувьд эрүүл байх;

Тав. Сайн дурын хэсгийн зохион байгуулалт

5.1.Орон нутгийн гамшиг, ослын нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сайн дурын хэсгийг орон нутгийн Засаг даргын шийдвэрээр байгуулна.

5.2.Сайн дурын хэсгийн ажилтныг “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар”-ын дагуу бүртгэнэ. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны зааврыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

5.3.Тусгай хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж, үүрэг гүйцэтгэх мэдлэг, чадвар эзэмшсэн сайн дурын хэсгийн ажилтанд орон нутгийн онцгой байдлын байгууллагаас гэрчилгээ, үнэмлэх олгож, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцуулна. Хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаагүй бол гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцуулахгүй.

5.4.Сайн дурын хэсэг нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохдоо тухайн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байгаа онцгой байдлын байгууллагын албан хаагч, бусад албан тушаалтны удирдлага дор үүрэг гүйцэтгэнэ.

5.5.Сайн дурын хэсэг нь үйл ажиллагаагаа орон нутгийн Засаг дарга, онцгой байдлын байгууллагад тайлагнана.

5.6.Сайн дурын хэсгийн ажилтан байгуулсан гэрээ, ажлын чиг үүргээ биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн, ажил үүргээ сайн дураараа гүйцэтгэхээс татгалзсан, өөр орон нутагт шилжин суурьших болсон, цэргийн жинхэнэ албанд татагдсан, нас барсан, гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны гэрээг цуцалж, бүртгэлээс хасалт хийнэ.

Зургаа. Сайн дурын хэсгийн ажилтны эрх, үүрэг

6.1.Сайн дурын хэсгийн ажилтан дараах эрх эдэлнэ:

- 6.1.1.ажиллах нөхцөлөөр хангагдах;
- 6.1.2.ажлын чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл авах;
- 6.1.3.гамшиг, ослын бүсэд нэвтрэн үүрэг гүйцэтгэх;
- 6.1.4.ажуулгүй байдал, хувийн мэдээллээ хамгаалуулах;
- 6.1.5.эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдах;
- 6.1.6.сургалт, дадлагад хамрагдаж мэдлэг, чадвараа дээшлүүлэх.

6.2.Сайн дурын хэсгийн ажилтан дараах үүрэг хүлээнэ:

- 6.2.1.гамшгаас хамгаалах дайчилгаанд бэлэн байх, шаардлага гарсан тохиолдолд оролцох;
- 6.2.2.ажил эрхэлдэг бол ажил олгогчоос чөлөө, зөвшөөрөл авах;

- 6.2.3.байгуулсан гэрээ болон ажлын чиг үүргээ биелүүлэх;
- 6.2.4.үйл ажиллагаандаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг сахих;
- 6.2.5.өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, бусдад туслах;
- 6.2.6.гамшгаас хамгаалах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлаа холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнах;
- 6.2.7.гал түймэр, гамшиг осол гарсан тохиолдолд өөрийн хэмжээнд шуурхай арга хэмжээ авч, онцгой байдлын байгууллага, холбогдох албан тушаалтанд яаралтай мэдэгдэх;
- 6.2.8.хувь хүний болон нийгмийн ёс зүйн хэм хэмжээг сахих, байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцохгүй байх;
- 6.2.9.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг тасалдуулах, хэвийн явуулах нөхцлийг алдагдуулахад чиглэсэн аливаа арга хэмжээг зохион байгуулахгүй байх.

Долоо.Орон нутгийн Засаг дарга, онцгой байдлын байгууллагын эрх, үүрэг

7.1.Орон нутгийн Засаг дарга гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаанд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- 7.1.1.сайн дурын хэсгийн ажилтныг бүртгэх, сургаж бэлтгэх;
- 7.1.2.нутаг дэвсгэрийн онцлог, гамшиг, ослын нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сайн дурын хэсгийг байгуулах, татан буулгах;
- 7.1.3.сайн дурын хэсгийг үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай техник, багаж хэрэгсэл, хувцсаар хангах;
- 7.1.4.сайн дурын хэсгийн ажил үүргээ гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэх, шаардагдах зардлыг гаргах;
- 7.1.5.сайн дурын хэсгийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, үйл ажиллагаанд хяналт тавих;
- 7.1.6.сайн дурын хэсгийн ажилтантай гэрээ байгуулах, үр дүнг үнэлж дүгнэх;
- 7.1.7.сайн дурын хэсгийн ажилтны аюулгүй байдлыг хангах, эрхийг хамгаалах;
- 7.1.8.сайн дурын хэсгийн ажилтныг шагнаж урамшуулах, шагналд тодорхойлох, олон нийтэд сурталчлан таниулах;
- 7.1.9.гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд санал оруулж шийдвэрүүлэх

7.2.Орон нутгийн онцгой байдлын байгууллага гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаанд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- 7.2.1.сайн дурын хэсгийн ажилтныг элсүүлэх, сургаж бэлтгэхэд орон нутгийн Засаг даргад дэмжлэг үзүүлэх;
- 7.2.2.сайн дурын хэсгийн мэдээллийн санг бүрдүүлэх;
- 7.2.3.сайн дурын хэсгийн ажилтны ажлын чиг үүргийг тодорхойлж батлах;

7.2.4.сайн дурын аврагч, гал сөнөөгчийг тусгай хөтөлбөрийн дагуу сургаж бэлтгэх;

7.2.5.сайн дурын хэсгийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

7.2.6.сайн дурын хэсгийн ажилтныг онцгой байдлын албаны нэрэмжит шагналаар шагнаж урамшуулах, олон нийтэд сурталчлан таниулах;

7.2.7.сайн дурын хэсгийг байгуулах, бүрэлдэхүүнийг томилох, техник, багаж хэрэгслээр хангах асуудлаар орон нутгийн Засаг даргад заавар, зөвлөмж өгч мэргэжлийн удирдлагаар хангах;

7.2.8.сайн дурын хэсгийн бэлтгэл бэлэн байдал, үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжлийн дүгнэлт гаргах.

7.2.9.сайн дурын хэсгийн үйл ажиллагааг орон нутгийн онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдлын асуудал хариуцсан ажилтан хариуцна.

Найм.Сайн дурын хэсгийн сургалт, дадлага

8.1.Сайн дурын хэсгийн сургалт, дадлагыг батлагдсан хөтөлбөрийн дагуу орон нутгийн хэмжээнд Засаг дарга, онцгой байдлын байгууллагатай хамтран зохион байгуулна.

8.2.Сайн дурын хэсгийн сургалтын хөтөлбөрийг тухайн орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга батална.

Ес.Сайн дурын хэсгийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцуулах

9.1.Сайн дурын хэсгийг шаардлагатай үед нэгдсэн удирдлага, зохион байгуулалтад оруулж гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцуулна.

9.2.Сайн дурын хэсгийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцуулахдаа “Гамшгийн үед хүч хэрэгслийг дайчлан гаргах журам”-ын дагуу зохион байгуулна.

9.3.Сайн дурын хэсгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээг орон нутгийн Засаг дарга, сайн дурын хэсгийн ахлагч хариуцан зохион байгуулна.

9.4.Сайн дурын хэсэг нь шаардлагатай үед түргэн цугларах, үйл ажиллагаагаа явуулах тусгай заавар, төлөвлөгөөтэй байж болно.

Арав. Сайн дурын хэсгийн ажилтны нийгмийн баталгаа

10.1. Ажлаас чөлөөлөгдөн гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн сайн дурын хэсгийн ажилтныг үндсэн ажлаа хийсэнд тооцож, тухайн байгууллага нь цалин хөлсийг нь хэвээр нь олгоно.

10.2.Сайн дурын хэсгийн ажилтны ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах зардал, томилогдсон газарт очих, ирэх замын зардал, хоол, эмнэлгийн үзлэг, вакцинжуулалтад хамрагдах зэрэг зайлшгүй гарах зардлыг тухайн орон нутгийн Засаг дарга хариуцна.

10.3.Сайн дурын хэсгийн ажилтан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үед хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний гэр бүлд Галын аюулгүй байдлын тухай хуулийн 14.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 36.2 дахь хэсэгт заасны дагуу тэтгэмж, буцалтгүй тусламж олгоно.

10.4.Сайн дурын хэсгийн ажилтны байгуулсан гавьяа, зүтгэлийг үнэлж, шагнал олгох, дээд байгууллагын шагналд тодорхойлох, нийтэд алдаршуулан сурталчлах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

10.5.Сайн дурын хэсгийн ажилтанд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцсон ажлын үр дүнг харгалзан орон нутгийн Засаг дарга мөнгөн урамшуулал олгож болно.

Арван нэг.Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны санхүүжилт

11.1.Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

11.1.1.улсын болон орон нутгийн төсөв

11.1.2.олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө

11.1.3.төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлагдсан тусламж, хандивын хөрөнгө

11.1.4.бусад эх үүсвэр.

11.2.Сайн дурын хэсгийн үйл ажиллагааны зардлыг орон нутгийн Засаг дарга хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

---oOo---

МОНГОЛ УЛС
ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2017 оны ...дугаар
сарын ... –ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 34 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга (хошууч генерал Т.Бадрал)-д даалгасугай.

Гарын үсэг